

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Хоршооны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан заавар, журмыг хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоод хэрхэн хэрэгжүүлж байгаад Хорооноос хяналт тавих, шалгалт хийх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах талаар ерөнхий журмыг тогтооход оршино.

1.2. Энэхүү журамд дурдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно;

1.2.1. “Хоршооны хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа” гэдгийг хоршооны үйл ажиллагаанд Хоршооны тухай хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, хоршооны үндсэн зорилтууд хэрхэн хангаж байгааг хянан шалгадаг, хөндлөнгийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг дээд байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулах зорилгоор бүх гишүүдийн хурлаас сонгогдсон дотоод хяналтын байгууллагын үйл ажиллагааг;

1.2.2. “Хоршооны дотоод хяналтын систем гэж” хоршооны дүрэм, бүх гишүүдийн хурлаас баталсан бодлого, бизнес төлөвлөгөө, бусад зорилтуудыг хэрэгжүүлэх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргуулах, мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, заавар, журам, тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг хоршооны үйл ажиллагаанд мөрдүүлэхийг;

1.2.3. “Аудитын үйл ажиллагаа, аудитор, аудитын байгууллага, санхүүгийн тайланг баталгаажуулах гэдгийг “Аудитын тухай” хууль 1-д зааснаар;

1.2.4. “Хоршооны гишүүн” гэдгийг Хоршооны хууль, хоршооны дүрэмд заасны дагуу гишүүнээр элссэнээр хоршооны эд хөрөнгийн зохих хувийн өмчлөгч болж, хоршооны хуралд оролцох, саналын нэг эрх эдлэх, хоршооны удирдлагад сонгогдох, сонгох, хоршооны бизнес төлөвлөгөөг боловсруулахад оролцох, хадгаламж, зээлийн үйлчилгээ авах, тайлангийн жилийн эцэст хоршооны орлогоос хувь хүртэх хувь хүнийг;

---

<sup>1</sup> Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д: “аудитын үйл ажиллагаа гэж” аудитын байгууллагаас гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, үйл ажиллагааны болон татварын тайланг хянаж дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ. Мөн хуулийн 3-г “аудитор гэж” хуульд заасан шаардлагыг хангаж, аудитын байгууллагад аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэшсэн нягтлан бодогчийг хэлнэ. Мөн хуулийн 4-т: “аудитын байгууллага гэж” хуульд эрх бүхий байгууллагаас аудитын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийг хэлнэ. Мөн хуулийн 6-д “санхүүгийн тайланг баталгаажуулах гэж” аудитын үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг батлагдсан стандартын дагуу шалгаж, үнэн зөв болохыг нотолсон дүгнэлт гаргахыг;

1.2.5.“Иж бүрэн шалгалт” гэж батлагдсан хуваарийн дагуу Хорооноос батлагдсан удирдамжийн хүрээнд тодорхой үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материал, хоршооноос батлан гаргасан дүрэм, заавар, журам, шийдвэрүүдэд тулгуурлан үйл ажиллагааны үзүүлэлтийг бүхэлд нь нарийвчлан шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг;

1.2.6.“Хэсэгчилсэн шалгалт” гэж Хоршооны гишүүдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр эсхүл Хорооноос шаардлагатай гэж үзсэн нөхцөлд тухайн Хоршооны үйл ажиллагааны тодорхой хэсгийг асуудлын нэр төрлөөр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийг;

1.2.7.”Нийтийг хамруулсан шалгалт” гэж тодорхой нэгэн асуудлыг хэд хэдэн хоршоонд буюу бүх хоршоодын үйл ажиллагаанд хамруулан шалгаж үнэлэлт дүгнэлт өгөхийг;

1.2.8.“Зайнаас тавих хяналт” гэж тухайн хоршооноос ирүүлсэн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, бусад холбогдох мэдээ, мэдээллийг улирал бүр хүлээж авч, дүн шинжилгээ хийж, дүнгийн талаар тухайн хоршоонд мэдэгдэж, зөрчил дутагдлыг арилгах, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж, шаардлага өгөхийг.

1.3.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хоршооны үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд Хорооны даргын томилсон хянан шалгагч /улсын байцаагч/ хийж гүйцэтгэнэ.

1.4.Хянан шалгагч /улсын байцаагч/ нь хоршоо болон иргэдийн санал, гомдлыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх ба боломжгүй нөхцөлд өөрийн харьяалах газрын дарга (ахлах улсын байцаагч), хорооны гишүүд (ахлах улсын байцаагч), Хорооны дарга (ерөнхий байцаагч)-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.5.Тухайн хяналт шалгалтыг хариуцаж буй газрын дарга шалгуулагч хоршоон дээр шалгалт хэрхэн явагдаж буйтай танилцаж, шаардлагатай асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлнэ.

## **ХОЁР. Шалгалтын зорилго, үе шат**

2.1.Хоршооны үйл ажиллагаанд хийх шалгалтын зорилго нь тухайн хоршооны үйл ажиллагаанд оршиж буй хүндрэлтэй асуудал, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, хүлээж болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хоршооны гишүүдийн дундын өмч, гишүүдийн хадгаламжийг хамгаалах, санхүүгийн тайлан мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг дүгнэх, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхийг шалган тогтоож, хоршооны санхүүгийн төлбөрийн чадварыг тодорхойлоход оршино.

2.2. Хоршоонд хийх шалгалт нь дараах үе шаттай явагдана:

2.2.1. Бэлтгэл хангах буюу шалгалтыг төлөвлөх;

2.2.2. Шалгалтыг явуулах;

2.2.3. Шалгалтын тайлан бичиж, дүгнэлт гаргах;

2.2.4. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.

2.3.Бэлтгэл хангах буюу төлөвлөлт хийх үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.3.1.Шалгалт хийх удирдамжийг Хорооны даргаар батлуулах, (Монголбанк болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч шалгалт хийх тохиолдолд хамтарсан удирдамж байна).

2.3.2.Хорооны улсын байцаагч, аймаг, дүүргийн ЗДТГ-ын СЭЗБХ-ийн бүртгэлийн улсын байцаагч нь хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийхдээ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулах харилцааг зохицуулж буй Монгол улсын хууль тогтоомж, бусад холбогдох журам, заавар, зөвлөмж болон тухайн шалгуулагч хоршоотой холбоотой бусад бичиг баримт, мэдээ мэдээллийг урьдчилан бэлтгэсэн байна. (Тухайлбал: санал, гомдол, хууль бус үйл ажиллагаатай холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл, өмнөх шалгалтаар өгсөн үүрэг, даалгавар гэх мэт).

2.4.Шалгалтыг явуулах үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.4.1.Улсын байцаагч нь хоршооны үйл ажиллагаанд шалгалт хийж эхлэхдээ батлагдсан удирдамжийн нэг хувийг хоршоонд өгч, шалгалтад хамрагдах хугацааны тайлан тэнцэл болон шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах холбогдох баримт материалыг хариуцсан ажилтнуудаар нь гаргуулж авна. /Хүлээн авсан тухай акт үйлдэнэ/;

2.4.2.Шалгалтаар очсон эхний өдрөө Хоршооны дарга буюу гүйцэтгэх захирал, нягтлан бодогч (аль нэг албан тушаалтан байж болно), няравыг байлцуулан гүйлгээ кассын үлдэгдэл мөнгийг тоолж, журнал болон кассын дэвтрийн өдрийн үлдэгдэлтэй тулган шалгана. (Хэрэв шалгалт очих үед нярав байхгүй зэрэг шалтгаанаар кассыг тоолох боломжгүй бол холбогдох хүмүүсийг байлцуулан кассыг лацдаж, дараа нь тоолно);

2.4.3.Шалгалтаар илэрсэн зөрчил, төлбөр үүсч болзошгүй баримтуудыг нягтлан шалгах, асууж тодруулах, зөрчилтэй баримтын жагсаалтыг үйлдэх, нотлох баримтыг хуулбарлан авна;

2.4.4.Шалгалт дууссаны дараа шалгалтад ашигласан хоршооны санхүүгийн баримтыг хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэн хоршооны холбогдох ажилтнуудад хүлээлгэж өгнө.

2.5.Шалгалтын тайлан бичиж дүгнэлт гаргах үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.5.1.Шалгалтын тайланд хоршооны үйл ажиллагааны чиглэл бүрээр мөрдөж буй хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдал, түүнийг хариуцах эзэн, авсан арга хэмжээ, шалгалтын дүнгээр авах арга хэмжээний талаарх санал, өгсөн үүрэг, албан шаардлага, зөвлөмжийн талаар тусгана.

2.5.2.Шалгалтын ажлын дүнг үндэслэн Улсын байцаагчийн акт тогтоох, түүний гүйцэтгэлийг хангуулах, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, өгч, албан шаардлага тавина.

2.5.3.Төлбөр зөрчлийн актыг хууль тогтоомжийг зөрчсөн нь илэрсэн тохиолдолд тавьж, актад зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт болон харилцагч байгууллага, иргэдэд учруулсан хохирлын хэмжээг тодорхой дурдсан байна.

2.5.4.Шалгалтын тайланд дараах судалгааг заавал хавсаргана:

а/шалгах үеийн байдлаар гүйлгээ үлдэгдлийн баланс, тайлан тэнцэл, зээлийн дэлгэрэнгүй бүртгэлийн жагсаалт, үндсэн хөрөнгийн бүртгэлийн дэлгэрэнгүй, ӨБҮХХ-ийн дансны дэлгэрэнгүй бүртгэл, хадгаламжийн дансны дэлгэрэнгүй бүртгэлийн жагсаалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн судалгаа;

б/шалгалтын хугацаанд тавигдсан төлбөрийн акт, түүнд холбогдох бичиг, баримт, хуулбар, тодорхойлолт, тодруулга, лавлагааг хавсаргаж баталгаажуулсан байх;

в/шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт;

г/шалгалтын явцад болон шалгалтад хамрах хугацаанд иргэдээс ирүүлсэн санал гомдол, түүний мөрөөр авсан арга хэмжээг нотлох баримт бичиг, өгсөн хариу баримт бичиг;

д/хоршооны эдийн засгийн үзүүлэлт, холбогдох судалгаа, шинжилгээний материал.

2.6.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.6.1.Шалгалтын ажлын дүнг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн хугацаатай үүрэг, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд нь гаргуулан авч биелэлтийг шалгана,

2.6.2.Өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг биелүүлээгүй, этгээдэд хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэж, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг шалгалтын ажлын хэсэг /хянан шалгагч/ Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

### **ГУРАВ. Шалгалтын арга хэлбэр**

3.1.Хоршоонд хийх шалгалт нь иж бүрэн болон хэсэгчилсэн, нийтийг хамруулсан хэлбэрээр хийгдэж болно.

3.2.Иж бүрэн шалгалтыг удирдамжийн дагуу тухайн хоршооны дохиолол болон хамгаалалт, тоног төхөөрөмж, актив, пассив, дундын өмч, тэнцлийн гадуурх данс, бизнес төлөвлөгөө, удирдлагын мэргэжлийн ур чадвар, уг хоршооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварт үнэлэлт дүгнэлт өгөх ба хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг тооцож гаргана.

3.3.Хэсэгчилсэн шалгалтын үед энэ журмын 3.2-т заасан, эсхүл хэд хэдэн чиглэлийг хослуулан хийж болох бөгөөд шаардлагатай бол тухайн хоршоог анх үүсгэн байгуулсан 20 гишүүн, хууль хяналтын холбогдох байгууллагад тухайн гишүүнтэй холбогдох асуудал шалгагдаж буй хэсгийг шалгаж болно.

3.4.Нийтийг хамруулсан шалгалтын үед энэ журмын 3.3-т заасан зүйлүүдээс тодорхой нэгэн асуудлыг хэд хэдэн хоршоонд эсвэл бүх хоршоонд нэгэн зэрэг, нэгэн өдрийг тасалбар болгон нэгэн ижил цаг хугацааны баримтанд тулгуурлан шалгаж болно.

3.5.Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах бөгөөд хэрэв гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл холбогдох хуулийн байгууллагад асуудлыг шилжүүлнэ.

3.6.Шалгалтын явц, үр дүнг шалгуулагчид танилцуулан холбогдох заавар, зөвөлгөө өгч шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах бөгөөд шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр шалгана.

3.7.Нэгдсэн буюу нийтийг хамруулсан шалгалтын эцсийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч нэгтгэж гаргах бөгөөд дүгнэлтэд шалгаж буй хоршооны онцлог, явуулж буй үйл ажиллагааны эрсдлийн төвшин, дундын өмч, зээлийн багц, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг онцлог зүйлүүдийг тусгасан байна.

3.8.Хяналт, шалгалтын ажлын үндсэн зорилгыг хангах үүднээс шаардлагатай асуудлыг магадлах, тодорхой мэргэжил, мэргэшлийн дэмжлэг авах, дүгнэлт гаргуулах зорилгоор шалгалтанд Хорооны тухайн асуудлыг хариуцсан улсын байцаагч, Монголбанк болон холбогдох мэргэжлийн байгууллагын мэргэжилтэн, улсын байцаагчийг татан оролцуулж болно.

3.9.Хоршооны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөхдөө активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагаа, эрсдлийн мэдрэмж, удирдлагын чадварын талаарх дүгнэлт болон зохистой харьцааны дараах үзүүлэлтүүдэд үндэслэнэ:

3.9.1.Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд;

3.9.2.Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой, эрсдэлгүй байдлыг хангах ажиллагааны хүрээнд ажиллаж байгаа;

3.9.3.Актив хөрөнгийн хамгаалалтын үзүүлэлт;

3.9.4.Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;

3.9.5.Актив хөрөнгийн чанарын үзүүлэлт;

3.9.6.Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;

3.9.7.Төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцно.

#### **ДӨРӨВ. Хяналт шалгалт**

4.1.Хянан шалгагч нь шалгалтыг дараах үндсэн чиглэлийг удирдлага болгон хийнэ:

4.1.1.Хоршооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа;

4.1.2.Хөндлөнгийн хяналт;

4.1.3.Актив хөрөнгө;

4.1.4.Өр төлбөр буюу пассив хөрөнгө;

- 4.1.5.Хоршооны өмч буюу өөрийн хөрөнгө;
- 4.1.6.Тэнцлийн гадуурх дансны гүйлгээ;
- 4.1.7.Бусад асуудал.

4.2.Шалгалтын ажлын хэсгийн ахлагч буюу улсын байцаагч нь тухайн хоршооны удирдлагын бүтэц болон үйл ажиллагааны талаар нэгдсэн дүгнэлт хийж, хоршоо нь хууль тогтоомж, Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлага болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилт, хэрэв шаардлага хангахгүй гэж үзсэн тохиолдолд энэ талаар өөрийн дүгнэлтийг шалгалтын тайланд тусгана.

#### **ТАВ. Хоршооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг шалгах**

5.1.Улсын байцаагч нь хоршооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлүүдийг онцгойлон авч үзнэ:

5.1.1.Хяналтын зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны дотоодын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан, мэргэжлийн чадвартай ажилтнуудаас бүрдсэн эсэх;

5.1.2.Хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж, дотоод хяналт шалгалт нь тогтмол хугацаанд хийгдэж, Хоршооны үйл ажиллагааг бүхэлдээ хамруулан шалгаж, бүх гишүүдийн хуралд тайлагнасан, Тэргүүлэгчдийн хурал, Хоршооны даргад танилцуулдаг эсэх;

5.1.3.Хяналтын зөвлөл нь Хоршооны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг 3.9 дэх хэсэгт заасан нөхцөл, шаардлага, шалгуураар үнэлж, дүгнэхээс гадна хоршооны үйл ажиллагаанд учирч болох эрсдлийг тооцож ажилладаг эсэх;

5.1.4.Хоршоо нь бүх гишүүдийн хурлаас Хяналтын зөвлөл, түүний гишүүдийг сонгох ба зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, огцруулах, хасах асуудлыг Хяналтын зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэдэг эсэх;

5.1.5.Хяналтын зөвлөл нь Хоршооны тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг Хоршооны тухай хууль тогтоомж, Хоршооны дүрэм болон Хорооноос баталсан заавар, журам, бизнес төлөвлөгөө, зөвлөмж, чиглэлийг удирдлага болгон хэрэгжүүлдэг эсэх;

5.2.Хянан шалгагч нь тухайн хоршооны Хяналтын зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь шаардлага хангаж, хоршооны үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, энэ талаар шалгалтын тайланд тусгана.

5.3.Шалгалтыг хоршооны Хяналтын зөвлөлийн хийсэн ажлын тайлан, түүний гаргасан шийдвэрийг үндэслэж, Хяналтын зөвлөлийн гишүүдтэй ярилцлага хийх хэлбэрээр явуулна.

#### **ЗУРГАА.Хөндлөнгийн хяналт**

6.1.Хянан шалгагч нь хоршооны санхүүгийн тайланг хөндлөнгийн хяналт буюу аудитын байгууллагаар баталгаажуулсан эсэхийг шалгахдаа дараах зүйлийг анхаарна:

6.1.1.Аудитор нь тухайн хоршооноос хараат бус эсэх;

6.1.2.Хоршооны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор шалгасан эсэх болон судалсан тайлан, санхүүгийн баримтад хувийн тэмдэг дарж, түүний гаргасан дүгнэлтэд аудитын байгууллагын дарга (захирал) гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулсан эсэх.

6.2.Хөндлөнгийн хяналт, шалгалтаар уг хоршооны санхүүгийн тайланд залруулгын гүйлгээ болон зөвлөмжүүдийг өгсөн бол түүний хэрэгжилтийг шалган шалгалтын тайланд дүгнэлт бичнэ.

6.3.Шалгалтаар аудитын байгууллага илтэд буруу, алдаатай санхүүгийн тайланг баталгаажуулсан нь тогтоогдвол холбогдох дээд байгууллагад нь албан тоотоор мэдэгдэх буюу шаардлагатай арга хэмжээг авна.

## ДОЛОО. Актив хөрөнгө

Хоршооны актив хөрөнгийн үйл ажиллагааг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг тогтооно:

7.1.Хоршооны дүрэм болон Хоршооны тухай хууль<sup>2</sup>-д заасны дагуу үйл ажиллагаандаа мөрдөж байгаа заавар, журам, бодлогын чанартай бичиг баримт гарсан байдал;

7.2. Хоршооны активын бүтцийг орлого авчирдаг актив, орлого авчирдаггүй актив гэж бүлэглэн, орлого авчирдаг активын хувьд зээлийн чанарыг гол үзүүлэлт болгож, гишүүдийн хадгаламжийн хэчнээн хувийг зээл болгосон, үүнээс хэчнээн нь чанаргүй зээлд байгаа зэргээр активыг тооцож гаргах.

7.3.Хоршоо нь мөнгөн хөрөнгө буюу кассын ажиллагааны аюулгүй байдлыг хангасан эсэхийг шалгахдаа дараах зүйлсийг тогтооно:

7.3.1.Кассын өрөө, тасалгаа нь нийтийн болон албаны бусад өрөө, тасалгаанаас бөх найдвартай цонх, хаалга, цоож бүхий хаалт, хашилгаар тусгаарлагдсан эсэх;

7.3.2.Кассын ажилтны хариуцсан мөнгөн тэмдэгтийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг сэйфэнд дэх бэлэн мөнгө буюу кассын гүйлгээ үлдэгдэл (сэйф, шүүгээг лацаар лацдах, ломбоддог)-ийг нягтлан бодохын баримттай тохирч байгаа эсэх (бэлэн мөнгийг ширхэгчлэн тоолно/;

7.3.3.Хоршооны кассын баримтад давхар хяналт буюу үнэн зөвийг баталж гарын үсгээр баталгаажуулдаг эсэх;

7.3.4.Хоршооны Хяналтын зөвлөлөөс кассын ажиллагаанд гэнэтийн болон тогтмол шалгалтын аль нэгийг Хоршооны дүрэм болон холбогдох заавар, журамд заасны

---

<sup>2</sup> Хоршооны тухай хуулийн 48<sup>1</sup>2-т Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь дараах асуудлыг дүрэмдээ тусгана,  
Мөн хуулийн 48<sup>3</sup> дахь зүйлд Хоршооны зээлийн үйл ажиллагаа,  
Мөн хуулийн 48<sup>4</sup> дүгээр зүйлд Зээлийн хороо, түүний бүрэн эрх, бүрэлдэхүүн

дагуу хийсэн эсэх, баримтаар болон биетээр бүрдлийг шалгаж дүгнэсний дараагаар кассын баримтын үнэн зөвийг баталж гарын үсгээр баталгаажуулдаг эсэх;

7.3.5. Анхаарал татсан өөрчлөлт болон их хэмжээний бэлэн мөнгөний хөдөлгөөнийг шаардлагатай бол нарийвчлан шалгах;

7.3.6. Хоршоо нь бэлэн мөнгөний талаарх бодлого, үйл ажиллагаа, заавар, журам болон бэлэн мөнгөний талаарх зөрчил дутагдлыг засан залруулах арга хэмжээ авах чадвартай байгааг тогтоож үнэлэлт, дүгнэлтийг гаргаж, энэ талаар шалгалтын тайланд тусгах;

7.4. Богино хугацаатай хөрөнгө оруулалт, зээлийн үйл ажиллагааг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг шалгана:

7.4.1. Шалгалтын хугацаа, шалгах хүрээнээс шалтгаалан богино хугацаат хөрөнгө оруулалт, зээлийн хувийн хэргийг 100 хувь буюу хувь тогтоох, түүврийн аргаар шалгах;

7.4.2. Шалгалт эхэлсэн өдрийн тайлан тэнцлийг авч, зээлийн дансны үлдэгдлийг зээлдэгчийн нэр, дансны дугаартай дэлгэрэнгүйгээр гаргуулан үлдэгдлийг нэгбүрчлэн шалгах;

7.4.3. Хоршооноос зээлийн хувийн хэргийг акт үйлдэн хүлээн авч, тайлан тэнцлийн үлдэгдэлтэй тулган шалгах, зээлийн хувийн хэрэг дутуу бол дутуу байсан шалтгааныг шалгалтын тайланд тодорхой бичих бөгөөд зээлийн хувийн хэргийг шалгахдаа дараах материалын бүрдэлтийг шалгана:

7.4.3.1. Гишүүн зээлдэгч зээл хүссэн өргөдлөө бичгээр гаргасан эсэх;

7.4.3.2. Зээлийн хорооны хурлын протокол, хурлаас гарсан зээл олгох сунгах шийдвэр, зээлийн гэрээ байгаа эсэх;

7.4.3.3. Зээлдэгч нь хоршооны гишүүн мөн эсэх, хоршооны гишүүн гэсэн гэрчилгээ, гэрчилгээний огноо, дугаар байгаа эсэх;

7.4.3.4. Зээлдэгч бүрд зээлийн хувийн хэрэг нээсэн эсэх;

7.4.3.5. Гишүүнээс барьцаа болгосон хөрөнгө байгаа эсэх, хэний эзэмшилд байгаа (барьцааны хөрөнгө нь хамтран эзэмшигч байгаа бол зөвшөөрөлтэй эсэх);

7.4.3.6. Зээлдэгчийн эдийн засгийн тооцоо хэр үндэслэлтэй байгаа, хоршооноос авсан зээл, зээлийн хүүгийн хамт бүрэн төлөх найдвартай эсэх;

7.4.3.7. Зээлийн үндсэн өрийн үлдэгдэл болон зээлийн хүүгээ төлж байгаа, зээл төлөх төлбөрийн нөхцөлийг хэний шийдвэрээр өөрчилсөн талаар албан ёсны шийдвэр байгаа эсэх;

7.4.3.8. Шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.



7.4.4.Тухайн хоршооны зээлийн бодлого, заавар, журамтай танилцаж, удирдамжид батлагдсан хугацааны зээлийн ангиллыг<sup>3</sup> хийж, уг хоршооны зээлийн талаарх заавар, журам, тухайн хоршооны тайлан тэнцэл дэх эрсдлийн сангууд нь дээрх журамтай нийцсэн эсэх, эрсдлийн сангуудын илүү, дутуу байгуулсныг шалгах,

7.4.5.Зээлийн багц нь орлого авчирдаг актив учраас тухайн хоршоо ард иргэдийг хоршооны гишүүнд хуурамчаар элсүүлэн зээл олгосон эсэхийг анхааран нарийвчлан шалгах, шаардлагатай гэж үзвэл зээлдэгчтэй биеэр уулзаж үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.4.6.Хоршооны Хяналтын зөвлөлөөс зээлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг Хоршооны тухай хууль, дүрэм болон холбогдох заавар, журамд заасны дагуу хийдэг эсэх, зээл олгох, шийдвэр гаргах явц, зээл төлүүлэх туршлага, арга хэмжээ, эргэн төлөлт, үүсч болзошгүй хүндрэлүүд, чанаргүй зээлийн хувь хэмжээ, (зээлийн үндсэн өр болон хүү нь өөрчлөгдсөн, эсвэл төлөгдөх хугацаа нь хойшлогдсон, мөн зээл төлөх төлбөрийн нөхцөл гэрээ нь бусад өөр аргаар өөрчлөгдсөн эсэх) зэргийг хянах;

7.4.7.Хоршооны Хяналтын зөвлөл нь зээлийн эрсдлийн сангийн данснаас (хасагдуулга) зарцуулсан гүйлгээ бүрийг шалгаж хэзээ, хэний, шийдвэрээр хийгдсэн зэрэгт хяналт тавьсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

7.4.8.Улсын байцаагч шалгалт эхэлсэн өдрийн санхүүгийн тайланг гаргуулан авсны дараагаар зээлийн ангиллыг шинээр хийж, зээлийн эрсдлийн сангийн тооцоог шалгалт дууссан тухайн өдөр зээлийн ангиллын дагуу гүйлгээг хийлгэж, зээлийн эрсдлийн санг илүү байгуулсан бол гүйлгээг буцаах, дутуу байгуулсан бол гүйлгээний зардлаас шууд байгуулах арга хэмжээг авна.

7.5.Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цаашид ӨБҮХХ гэх)-ийг шалгахдаа зээлийн барьцаанд хураагдсан үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бүртгэх болон түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулдаг “Иргэний хууль” болон Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбогдох бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

7.5.1.ӨБҮХХ-ийг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг шалгана:

7.5.1.1.Шалгалт хамрах хугацааны санхүүгийн тайланд тулгуурлан ӨБҮХХ-ийг холбогдох журмын дагуу данс бүртгэлд бүртгэсэн эсэх;

7.5.1.2.Тухайн дансны хөдөлгөөн, өөрчлөлтийг тодорхойлж, өөрчлөлт орсон дансыг санхүүгийн тайлангаас тухайн гүйлгээ гарсан өдрийг тогтоож, гүйлгээ гарсан өдрийн мемориалын эсвэл кассын баримт дахь гүйлгээ хийсэн баримтыг “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлал” болон хоршооны баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу хийсэн эсэх;

7.5.1.3.ӨБҮХХ-ийг хэний шийдвэрээр хураан авсан, гүйлгээ хийсэн огноо, хураан авсан эд зүйлсийн үнийг хэний шийдвэрээр үнэлснийг тодорхойлох, (Шүүхийн шийдвэр, үл хөдлөх хөрөнгийн газрын үнэлгээ, өр барагдуулах алба гэх мэт);

---

<sup>3</sup> Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны хамтарсан 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан өөрчлөлт (хамтарсан 147/94 тоот тушаал)

7.5.1.4.ӨБҮХХ-ийн эрсдлийг тооцож, ӨБҮХХ-ийн чанарыг шалгахдаа холбогдох журам<sup>4</sup>-д заасан хугацаа болон хүчин зүйлийг үндэслэн тогтоосон хувь хэмжээгээр эрсдлээс хамгаалах санг байгуулсан эсэх;

7.5.1.5.ӨБҮХХ-ийг тайлан тэнцэлд тусгахдаа холбогдолтой зээлийн дүн, борлуулах зах зээлийн үнэлгээ хоёрын аль багаар нь бүртгэсэн эсэх;

7.5.1.6.Борлуулахад орох орлого, гарах зардлыг тухайн тайлант хугацааны цэвэр орлогод оруулсан эсэх, (борлуулах зах зээлийн үнэлгээ бурсан тохиолдолд ӨБҮХХ-ийн үнэлгээний хасагдуулгын зардлаар бүртгэсэн эсэх);

7.5.1.7.ӨБҮХХ нь улсын бүртгэлд бүртгэгдэж, тухайн хөрөнгийн эзэмшигч этгээд нь түүний хууль ёсны өмчлөгч мөн болохыг баталгаажуулан олгосон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн Улсын бүртгэлийн гэрчилгээтэй эсэх;

7.5.2.Хяналтын зөвлөл нь ӨБҮХХ-д шалгалт хийдэг эсэх, шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар шалгалтын тайланд тусгана.

## 7.6. Үндсэн хөрөнгийн чанар, бүртгэл

7.6.1. Хоршоо нь үндсэн хөрөнгийг хэрхэн бэлтгэсэн болон тайлан тэнцэлд хэрхэн бүртгэснийг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг тогтооно:

7.6.1.1.Үндсэн хөрөнгийг тайлан тэнцлийн холбогдох дансны үлдэгдэлтэй тулгах, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь нэг бүрчлэн тоолж шалгах;

7.6.1.2.Хяналтын зөвлөл (үндсэн хөрөнгө тоолж шалгах ажлын хэсэг) нь үндсэн хөрөнгийг жилд нэгээс доошгүй удаа тоолж, нэг бүрийн үнэлгээг карт болон тэнцлийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулдаг эсэх, элэгдэл хорогдлыг холбогдох заавар, журмын дагуу тоолдог эсэх;

7.6.1.3.Шаардлагатай тохиолдолд үндсэн хөрөнгийг бэлтгэх, худалдан авах, шилжүүлэх, шилжүүлэн авах, ашиглалтаас хасах, борлуулах, засварлах, элэгдэл тооцох зэрэгтэй холбогдон гарсан гүйлгээг түүвэрчлэн үндсэн баримттай тулган шалгах;

7.6.1.4.Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн эсэх, үнэлсэн бол хэний, хэзээний шийдвэрээр хэрхэн үнэлүүлснийг шалгах;

7.6.1.5.Санхүүгийн түрээсээр үндсэн хөрөнгө авсан эсэх, авсан бол санхүүгийн түрээсийн гэрээ, нөхцөл, данс бүртгэлийг холбогдох журмын дагуу үнэн зөв хөтөлсөн эсэх.

7.6.2.Шалгалтаар шалгуулагч хоршооны хяналт нь үндсэн хөрөнгөтэй холбоотой эрсдлийг илрүүлэн тогтоох, эрсдлийг бууруулахад хяналт тавьж байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгнө.

7.6.3.Шалгалтаар үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчил тогтоогдвол улсын байцаагч холбогдох журмын дагуу зохих гүйлгээг хийлгэнэ.

---

<sup>4</sup> Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны хамтарсан 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан өөрчлөлт (хамтарсан 147/94 тоот тушаал)

## 7.7.Бусад авлага.

7.7.1.Улсын байцаагч бусад активыг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг шалгана:

7.7.1.1.Хяналтын зөвлөл нь бусад активын бүтцийг судалж, данс тус бүрээр дэлгэрэнгүй жагсаалт гаргаж тайлан тэнцлийн үлдэгдэлтэй тулган шалгасан эсэх;

7.7.1.2.Байгууллага, иргэдээс авах авлагыг жагсаалтаар гаргаж, түүвэрчлэн хэзээ, хэний шийдвэрээр олгосон, хэзээ төлүүлэх зэргээр учир шалтгааныг тодруулах;

7.7.1.3.Хяналтын зөвлөл нь авлагыг барагдуулахад тогтмол хяналт тавьж ажилладаг эсэх, зохих журмын дагуу эрсдлийг тооцон авлагын болзошгүй эрсдлийн санг<sup>5</sup> байгуулсан эсэх;

7.7.1.4.Сангийн данснаас зарцуулсан гүйлгээ нэг бүрийг хэзээ, хэний шийдвэрээр хийгдсэн болохыг тогтоож, үндсэн баримттай нь тулгах;

7.7.1.5.Зээлийн хүүг хуримтлуулан тооцож байгаа байдал, данс бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийг хөтлөх журмын дагуу хөтөлдөг эсэх;

7.7.1.6.Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан дансдын үлдэгдлийг судалж данс тус бүртэй холбогдох гэрээ хэлцэл, хугацаа, хүү, төлбөрийн нөхцөлийг судлах.

7.7.2.Тухайн хоршооны Хяналтын зөвлөл нь хоршооны актив хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Хорооноос баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож эрсдлээ удирдаж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, шаардлага хангахгүй тохиолдолд энэ талаар өөрийн дүгнэлтийг шалгалтын тайланд тусгана.

7.7.3. Шалгалтаар эрсдлийн санг илүү, дутуу байгуулсан, бусад активын данс бүртгэлтэй холбоотой зөрчил тогтоогдвол улсын байцаагч холбогдох журмын дагуу зохих гүйлгээг хийлгэнэ.

## НАЙМ. Өр төлбөр буюу пассив хөрөнгө

8.1.Хоршооны актив хөрөнгийн чанарыг шалгахдаа уг Хоршооны дүрэм болон Хоршооны тухай хуулийн 48<sup>1</sup>2-т заасны<sup>6</sup> дагуу үйл ажиллагаандаа мөрдөж байгаа заавар, журам, бодлогын чанартай бичиг баримт гарсан эсэхийг шалгасны дараагаар харилцах, хадгаламжийн бүтцийг тодорхойлно.

<sup>5</sup> Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны хамтарсан 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан өөрчлөлт (хамтарсан 147/94 тоот тушаал)

<sup>6</sup> Хоршооны тухай хуулийн 481.2-т Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь дараах асуудлыг дүрэмдээ тусгана

8.2.Өр төлбөр буюу пассив талыг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг тогтооно:

8.2.1.Тухайн хоршооны Хяналтын зөвлөлийн шалгалтын материалыг авч шалгалт хамрах хугацаанд (жилийн тайланг бүх гишүүдийн хурлаар баталсан эсэх) зөрчил дутагдал илэрч байсан эсэх, зөрчлийн мөрөөр авсан арга хэмжээг биелүүлсэн эсэхийг;

8.2.2.Шалгалт эхэлсэн өдрийн болон шалгалт хамрах хугацааны тайлан тэнцлээс гишүүдийн хадгаламжийн эх үүсвэрийн ерөнхий динамикийг гаргаж хэт их өссөн буюу буурсан сард анхаарлаа хандуулан дүрэмд заасан гишүүнээс хоршоонд оруулах хөрөнгийн дээд хэмжээг зөрчсөн эсэх, (үүсвэрийн бүтцийг тодорхойлно);

8.2.3.Тухайн сар, улиралд эх үүсвэр их хэмжээгээр өссөн буюу буурсан шалтгааныг тогтоохдоо өдрийн хураангуй гүйлгээ үлдэгдлийн тэнцлээс (ноорог дэвтрээс) аль өдөр өөрчлөлт орсон, ямар хадгаламжийн дансанд өөрчлөлт орсон зэргийг тус тус мэдэж, касс болон мемориалын үндсэн баримтаар баталгаажуулна:

8.2.3.1.Нийт хэдэн хадгаламжийн данс үлдэгдэл (үүнд нэг гишүүнээс оруулсан хөрөнгийн хэмжээ, хадгаламжийн дансны тоо)-тэй байгааг нягтлан бодох бүртгэлийн программаас шалгаж гүйлгээ үлдэгдлийн тэнцэлтэй тулгах;

8.2.3.2.Гишүүдийн хадгаламжийн дансыг зөв дансанд бүртгэсэн эсэхийг дэлгэрэнгүй гүйлгээ үлдэгдлийн тэнцлээс дансын үлдэгдлээр, гүйлгээ хийсэн касс, мемориалын баримтыг үзэх замаар шалгах;

8.2.3.3.Хэрэв Хяналтын зөвлөлөөс гишүүдийн хадгаламжийн дансаар хийгдсэн гүйлгээний баримтын бүрдэлтэнд тогтмол шалгалт хийдэг бол хэсэгчлэн шалгах;

8.2.3.4.Хяналтын зөвлөлөөс тогтмол шалгалт хийдэггүй гишүүдийн хадгаламжийн данснаас баримтгүйгээр зарлагын гүйлгээ хийсэн эсэх, хадгаламжийн зарлагын гүйлгээнд баталгаат гарын үсэг зурагдсан эсэх, гарын үсгийн баталгаатай тохирч байгаа эсэхийг шалган тогтоох, мемориалын ордероор хадгаламж эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хасалт хийсэн эсэх;

8.2.3.5.Гишүүдийн хадгаламжийн хүүг үнэн зөв боддог эсэхийг хадгаламжийн карт (дансны хуулга)-ыг үзэж, хүүг бодох замаар шалгах;

8.2.3.6.Бусад санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татсан бол ямар зорилгоор татсан, түүний төлөлтийн явцыг хоорондын гэрээ, тэнцэл, касс, мемориалын баримтыг үндэслэн шалгах;

8.2.3.7.Нийт эх үүсвэрт бусад санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр нь хэдэн хувийг эзэлж байгаа, зохих данс бүртгэлд тусгасан эсэх, тайлангийн хугацаанд тогтмол үлдэгдэлтэй байсан эсэхийг тайлан тэнцэл, касс, мемориалын баримтыг үндэслэн шалгах;

8.2.3.8.Өглөгийн дансыг нэр тус бүрээр нь дэлгэрэнгүй тэнцлээс гаргаж, касс, мемориалын баримтаар баталгаажуулах, шалгалт хамрах хугацаанд өглөгийн данс тогтмол үлдэгдэлтэй байсан эсэх.

8.2.4.Хоршоо нь Хяналтын зөвлөлийн болон хөндлөнгийн бусад хяналт шалгалтаар илэрсэн өр төлбөр буюу пассив хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдлуудыг бүх гишүүдийн хуралд танилцуулж, зохих арга хэмжээг авдаг эсэх.

8.3.Улсын байцаагч нь шалгалтын үед тухайн хоршооны хүүд мэдрэмтгий актив пассивын зөрүүг дараах томъёоллоор тооцоолж гаргана:

Хүүгийн цэвэр орлого = Хүүгийн орлого - Хүүгийн зарлага

Нэгж активаас олох (Хүүгийн орлого-Хүүгийн зарлага)  
Хүүгийн цэвэр Орлого = Орлого авчирдаг актив  
Орлого

8.4. Тухайн хоршооны Хяналтын зөвлөл нь хоршооны өр төлбөр буюу пассив хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Хорооноос баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож эрсдлээ удирдаж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, шаардлага хангахгүй тохиолдолд энэ талаар өөрийн дүгнэлтийг шалгалтын тайланд тусгана.

#### ЕС. Өөрийн хөрөнгө (Хоршоологчдын өмч)

9.1.Өөрийн хөрөнгийг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг тогтооно:

9.1.1.Хоршооны өөрийн хөрөнгө нь гишүүдээс нийлүүлсэн хувь хөрөнгө, дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар, хоршооны үйл ажиллагааны орлогоос нөөцийн санд хуваарилсан хөрөнгө, хоршоонд бэлэглэсэн, хандивласан хөрөнгө зэргээс бүрдэх бөгөөд эдгээр нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу бүртгэгдсэн эсэх;

9.1.2.Хяналтын зөвлөл нь хоршооны эд хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийг судалж, өөрийн хөрөнгө, гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн аливаа өөрчлөлтийг шалгасан эсэх;

9.1.3.Хоршооны гишүүн бүрт гэрчилгээ олгон баталгаажуулсан эсэх;

9.1.4.Хоршоо нь орлого хуваарилалтыг зөв тооцон гишүүддээ хуваарилсан, Хяналтын зөвлөл нь ногдол ашгийн хуваарилалтыг шалгасан эсэх;

9.1.5.Нөөцийн сан болон бусад санг холбогдох журам, Хоршооны дүрэмд заасны дагуу байгуулж, түүний зарцуулалтад хяналт тавьдаг эсэх;

9.1.6.Шалгалтын үр дүнгээр тухайн хоршооны бүх эрсдлийг даах хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэх;

9.1.7.Хоршоо нь Хяналтын зөвлөлийн болон хөндлөнгийн бусад хяналт шалгалтаар илэрсэн өөрийн хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдлуудыг дутагдал гаргасан хүмүүст танилцуулж, зохих арга хэмжээг авдаг эсэх;

9.2.Тухайн хоршооны Хяналтын зөвлөл нь хоршооны өөрийн хөрөнгө буюу хоршоологчдын өмчид хяналт тавьж, Хорооноос баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож эрсдлээ удирдаж чадаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, шаардлага хангахгүй тохиолдолд энэ талаар өөрийн дүгнэлтийг шалгалтын тайланд тусгана.

#### **АРАВ. Тэнцлийн гадуурх дансад**

10.1.Улсын байцаагч шалгуулагч хоршооны тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй аливаа хүлээж болзошгүй үүрэг, үнэ бүхий зүйл, зээл болон бусад активтай холбоотой тооцоог шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд дараах зүйлсийг тогтооно:

10.1.1.Тэнцлийн гадуурх дансдыг зориулалтын дагуу ашиглаж байгаа байдлыг Хяналтын зөвлөл шалгасан эсэх;

10.1.2.Зээлийн эрсдлийн сангаас хааж тэнцлийн гадуур бүртгэсэн зээлийг эргүүлэн төлүүлэх талаар зохиож байгаа арга хэмжээ, үр дүнг тооцох;

10.1.3.Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн бүртгэл, түүнийг төлүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгааг шалгах;

10.1.4.Шалгалтаар шалгуулагч хоршооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа нь тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа хөрөнгийн эрсдлийг илрүүлэн тогтоож, эрсдлийг бууруулахад хяналт тавьж байсан эсэх;

10.1.5.Хоршоо нь Хяналтын зөвлөлийн болон хөндлөнгийн бусад хяналт шалгалтаар илэрсэн тэнцлийн гадуурх дансадтай холбоотой зөрчил дутагдлуудыг арилгуулах арга хэмжээг авч бүх гишүүдийн хуралд танилцуулдаг эсэх;

10.2.Шалгалтаар тэнцлийн гадуурх дансадтай холбоотой зөрчил тогтоогдвол улсын байцаагч холбогдох журмын дагуу зохих гүйлгээг хийлгэнэ.

#### **АРВАННЭГ. Удирдлагын чадвар**

11.1.Удирдлагын чадварт үнэлэлт, дүгнэлт өгөхдөө энэ журмын бусад үзүүлэлтүүдийг гол болгохоос гадна дараах зүйлсийг нэмэлт үзүүлэлт болгоно:

11.1.1.Хорооноос хийсэн өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгавар, тогтоолын биелэлтийн байдал;

11.1.2.Холбогдох хууль, тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд улс орны эдийн засаг болон хоршооны салбарт гарч байгаа өөрчлөлтөд зохицуулан хоршооны үйл ажиллагааг удирдах чадвартай эсэх, хоршооны санхүүгийн байдалд бодит үнэлэлт дүгнэлт өгч, хоршооны стратегийг зөв тодорхойлж, зохистой шийдвэр гаргадаг эсэх;

11.1.3.Хоршоог оновчтой зохион байгуулж, ажилтныг шаардлагын хэмжээнд удирдан ажиллуулж чадаж байгаа эсэх;

11.1.4. Удирдлагын мэдээллийн систем бүрэлдэн бий болсон эсэх, хоршооны үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг хэрхэн цуглуулдаг, шаардлагатай бүх мэдээллийг хамардаг эсэх, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьдаг эсэх;

11.1.5. Хоршооны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцож, хяналт тавьж, эрсдлийг үнэлэх, бууруулах, хохирлыг нөхөх талаар арга хэмжээ авах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй таслан зогсоох, арилгах зэргээр хоршооны эрүүл саруул орчинг бүрдүүлж ажилладаг эсэх;

11.1.6. Хоршооны удирдах болон гүйцэтгэх ажилтнууд албан тушаалаа урвуулан ашиглаж байсан эсэх.

11.2. Улсын байцаагч нь хоршоонд хийх хяналт, шалгалтын тайланг батлагдсан удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд шалгалт эхэлсэн өдрийг тасалбар болгон авч, дээрх хүчин зүйлс нэг бүрээр үнэлэлт, дүгнэлтийг хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон бичиж, зөрчил илэрсэн бол зөрчлийн тухай тэмдэглэлийг хөтлөнө<sup>7</sup>.

### **АРВАНХОЁР. Улсын байцаагчийн үүрэг, хариуцлага**

12.1. Улсын байцаагч нь шалгах ажлын хүрээгээр үүсч болзошгүй эрсдлийг олж таних, илрүүлэх, түүнийг холбогдох газрын даргад танилцуулах, мэдээлэх, хугацаанд нь чанартай гүйцэтгэж, шалгалтын акт материалд бичигдсэн зөрчил, дутагдлыг тодорхой тоо баримтаар үнэн зөв бичнэ.

12.2. Хоршоонд хийсэн хяналт, шалгалттай холбогдон үүсэх хариуцлагыг тухайн хоршоонд шалгалт хийсэн улсын байцаагч хариуцна.

12.3. Улсын байцаагч тухайн хоршоотой холбогдох зөрчлийг санаатай дарагдуулсан буюу улсын байцаагчийн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бол Санхүүгийн зохицуулах хорооны ажилтны ёс зүйн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэмд заасны дагуу хариуцлага тооцно.

12.4. Ажлын хэсгийн ахлагч (Улсын байцаагч) нь шалгалтыг тогтоосон хугацаанд үр ашигтай хийж гүйцэтгэхэд ажлын хэсгийг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ шалгалтын явц, дүнгийн талаар болон шаардлагатай гэж үзсэн нөхцөлд шалгалтын удирдамжинд өөрчлөлт оруулах талаар саналаа Ажлын албанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

12.5. Журмын 3.2, 3.3-д заасан шалгалтын ажлын хэсгийн ахлагч шалгалтын удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоршооны удирдлагад танилцуулж, шалгалтыг эхлэх бөгөөд шалгалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгалтын дүнг Хорооны Ажлын албанд танилцуулсны дараа хоршооны удирдлагад танилцуулан гарын үсэг зуруулна. (Хорооны даргын тушаал гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор шалгалтын танилцуулга материал, зөрчлийн тэмдэглэл, улсын байцаагчийн шаардлага, мэдэгдэл зэргийг Хоршооны тэргүүлэгчдийн дарга, Хоршооны гүйцэтгэх захиралд тус тус албан тоотоор хүргүүлнэ) .

12.6. Хоршоо хариуцсан улсын байцаагч хоршооноос улирал бүр ирүүлсэн тайлан мэдээг хянаж, дүгнэлт бичсэний үндсэнд хоршоонд явуулах тайлангийн хариуг боловсруулж газрын даргад танилцуулж, түүний гарын үсэгтэйгээр албан тоотоор тухайн хоршоонд улирал бүрийн

---

<sup>7</sup> Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийг харах

дараа сарын дотор явуулна. Хоршооноос ирүүлсэн тайлангийн дагуу албан тоотоор явуулсан тайлангийн хариу нь тус хоршоонд авсан арга хэмжээнд хамаарахгүй.

12.7. Хэрэв тухайн зөрчил дутагдлыг анхны удаа гаргаж байгаа боловч ноцтой гэж улсын байцаагч дүгнэсэн тохиолдолд газрын даргад танилцуулна. Газрын дарга нь улсын байцаагчийн саналыг шаардлагатай тохиолдолд нэмж тодруулах зүйлсийг тодруулж, ажлын 1 хоногийн дотор дахин боловсруулсны эцэст Албаны дарга, Хорооны дарга нар танилцуулна.

12.8. Журмын 3.4-д заасан шалгалтыг ажлын хэсэг шалгалт хийсэн тухай шалгалтын нэгдсэн тайланг удирдамжийн заалт нэг бүрээр бичиж, авах арга хэмжээний талаар саналаа боловсруулан шалгалт хийж дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор Хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлж, түүний мөрөөр шийдвэр гаргуулна.

12.9. Шалгалтын явцад ажлын хэсгийн ахлагч улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, төлбөр, зөрчил, дутагдал нэг бүрт акт тогтоон засч, залруулах гүйлгээг шалгалт хийх хугацаанд хийлгүүлэн, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

12.10. Улсын байцаагч нь хоршоо ноцтой зөрчил дутагдал гаргасан буюу өмнөх зөрчил дутагдлыг дахин давтсан, энэ нь тухайн хоршооны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй буюу сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл тухайн хоршооны талаар танилцуулга бичиж, хоршоо хариуцсан хянан шалгагчаас зайнаас тавьсан урьдчилсан хяналтын дүгнэлтийг авч хавсаргаж Ажлын албаны дарга, Хорооны даргад танилцуулна.

12.11. Энэ журмын 12.10-д заасан танилцуулгад дараах асуудлуудын талаар тодорхой тусгасан байна:

12.11.1. Тухайн зөрчил нь холбогдох хууль тогтоомжийг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн,

12.11.2. Уг зөрчилтэй холбогдуулан авсан арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй жагсаалт,

12.11.3. Тухайн зөрчил, дутагдал гаргаснаар тухайн хоршооны санхүү төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлөх.

12.11.4. Зөрчлийг арилгах талаар авах арга хэмжээний талаарх санал.

### **АРВАНГУРАВ. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

13.1. Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн баталсан журам, заавар, Хорооны шийдвэр, шалгуур үзүүлэлтийг зөрчсөн зөрчил нь эрүүгийн хэргийн шинжтэй бол буруутай ажилтныг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээг авна.

13.2. Хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн баталсан журам, заавар, Хорооны шийдвэр, шалгуур үзүүлэлт, хэм хэмжээг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүний зөрчлийн шинж байдал, санаатай болон санамсаргүй ба хор уршиг, нийгэмд учруулсан хохирлын хэмжээ, зөрчил дутагдал давтагдсан зэргийг харгалзан захиргааны шийтгэл ногдуулна.

---oOo---